



**Монгол, япон зохиолын орчуулга дах үндэсний онцлог, соёлын
ялгааг хиймэл оюунаар шинжлэх нь**

Ц. Онон⁴⁷

Э. Тэргэл⁴⁸

Товчлол: Орчин үеийн нийгмийн салиггүй нэгэн хэсэг бол хиймэл оюун ухаан. Хиймэл оюун ухаан улам хөгжсөөр хүний зүрх сэтгэл, сэтгэл хөдлөлтэй нягт холбоотой уран зохиолын ертөнцөд ч хөл тавьжээ. Үүний нэгэн тод жишээ бол уран зохиолын орчуулга юм. Энэ өгүүллээр Ч. Лодойдамбын “Солонго” өгүүллэгийн япон орчуулга болон Акүтагава Рюносүкэгийн “Хамар” өгүүллэгийн монгол орчуулгыг хиймэл оюуны (ChatGPT) орчуулгатай харьцуулан үзэж, үндэсний онцлог, соёлын ялгааг илэрхийлэх үг хэллэгийг хиймэл оюун хэрхэн орчуулж буйг судлах болно.

Түлхүүр үг: Хиймэл оюун, ChatGPT, уран зохиолын орчуулга, үндэсний онцлог, соёлын ялгаа

Удиртгал

Google Translate, ChatGPT гэхчлэн цахим орчинд үнэгүй ашиглаж болох хиймэл оюуны орчуулгын программ өдрөөс өдөрт хөгжсөөр байна. Орчин үед хиймэл оюун ухаан нэг хэлнээс нөгөө хэл рүү энгийн үг, өгүүлбэрийг орчуулахаас гадна тууж, өгүүллэг гэхчлэн бүрэн хэмжээний зохиолыг богино хугацаанд “хялбархан” орчуулдаг болжээ. Зөвхөн орчуулах бус, бүрэн хэмжээний зохиолыг хүний гараар бүтсэн мэт бичиж, уран зохиолын дээд шагналыг хүртсэн тохиолдол ч бий. Тухайлбал, 2024 оны японы утга зохиолын хамгийн нэр хүндтэй Акүтагавагийн нэрэмжит шагналыг хүртсэн зохиолч Риэ Күтан хиймэл оюун ухаан ашиглаж зохиол бичсэн нь олны анхаарлыг татсанаас гадна цахим орчинд ихээхэн шүүмжлэл дагуулсан билээ. Риэ Күтан ярилцлагадаа “Зөвхөн дүрүүдийн асуулт хариулт хэсэгт хиймэл оюун ухаан ашигласан” гэжээ.⁴⁹

Энэ мэтчилэн хиймэл оюун ухаан хүний сэтгэл мэдрэмж шингэсэн уран зохиолын ертөнцөд ч хөл тавьж, орчуулахаас гадна “бичих” үйлийг мөн гүйцэтгэх болсон байна. Цаашид хиймэл оюун орчуулагчийн ажлыг зуун хувь гардан гүйцэтгэдэг болж, орчуулагч гэх мэргэжил үгүй болохыг үгүйсгэхгүй гэх хүмүүс ч цөөнгүй байна.

Васэда Их Сургуулийн багш Ли Жаэхо (2024) судалгаандаа дунд шатны япон хэлний хичээл үзэж буй герман оюутны зохион бичлэгийг багш болон хиймэл оюунаар (ChatGPT) уншуулж зөвлөмж бичих туршилт хийжээ. Туршилтаас харахад багш, хиймэл оюуны бичсэн зөвлөмжийн ихэнх хэсэг адилхан байснаас гадна хиймэл оюун гадаад оюутны бичсэн өгүүлбэрийн бүтэц,

⁴⁷ МУИС, ШУС, ХУС-ын Ази судлалын тэнхим, профессор

⁴⁸ Токиогийн Гадаад Судлалын Их Сургууль, магистрант

⁴⁹ 東京新聞ホームページ (2024) 「芥川賞作家・九段理江さん「受賞作の5%は生成AIの文章」発言の誤解と真意、AIある時代の創作とは」 < <https://www.tokyo-np.co.jp/article/310036> > (2024/9/26)

дүрмийн алдаа, үгийн зөв хэрэглээ зэргийг илүү нарийн задалж бичиж байсан бөгөөд хиймэл оюун болон багшийн бичсэн зөвлөмж бие биеийнхээ дутууг нөхөж буйг онцолсон байна.

Өгүүллэг, тууж зэрэг үргэлжилсэн үгийн зохиолыг хиймэл оюунаар орчуулахад тулгарах бэрхшээлийн нэг бол үндэсний онцлог бүхий үг хэллэг гэж хэлж болно. Үндэсний онцлог бүхий үг хэллэгийн талаар Р. Гүрбазар, Д. Дашдаваа, Ц. Хасбаатар, Г. Аким зэрэг олон эрдэмтэд судалжээ. Р. Гүрбазар (1996) үндэсний онцлог бүхий үгийг:

1. Галиглах
2. Хуулбарлах буюу үгчлэх
3. Ойролцоо утгатай үгээр орлуулах
4. Тайлбарлах арга гэсэн дөрвөн аргаар орчуулж болно гэжээ. Харин Д. Дашдаваа (1972)

“Үндэсний өвөрмөц онцлогийг харуулсан реалид тухайн орны ахуй амьдрал, шашин шүтлэг, түүх соёлын үзэгдлийн өвөрмөц байдлыг тусгасан үг хэллэг (зан заншил, хувцас хунар, хоол хүнс, орон байр, унаа уналгын) зэрэг ордог” гээд ийм үгсийг:

1. Галигчлах буюу транскрипци
2. Хуулбарлан буулгах буюу кальки (үгчилсэн орчуулга)
3. Тайлбарлан орчуулах
4. Орчуулгад зүүлт тайлбар хэрэглэх
5. Галигчилсан тайлбарт орчуулга
6. Утга ойролцоо үг хэллэгээр орчуулах гэсэн зургаан аргаар орчуулж болно хэмээн

тодорхойлжээ.

Монголын богино өгүүллэгийг хиймэл оюунаар орчуулж үзэх нь

Анх Японы түүхч Нака Мичиё (那珂通世) 1902 онд 12 бүлэг “Монголын Нууц Товчоо” номыг япон хэлнээ орчуулахаар сэтгэл шулуудаж манж, монгол хэлний толь ашиглан орчуулж эхэлснээр япон дахь монгол судлалын эх тавигдсан гэхэд хилсдэхгүй. Нака Мичиё (那珂通世) Монголын Нууц Товчоог орчуулахдаа хятад болон дорно дахины ном зохиолыг давхар судалж, барагцаагаар гурван жилийн хугацаанд орчуулгаа хийж гүйцэтгэсэн тухай японы түүхч Наками Тацүо (2009)⁵⁰ өөрийн судалгаандаа дурдсан байдаг.

Монголын орчин үеийн уран зохиолыг 1960-аад оноос япон хэл рүү орчуулж эхэлжээ. Арай Шиничиро, Озава Шигэо, Мацүда Таданори, Кайко Такэши, Шига Рюүтаро, Окада Казүюки, Камимүра Акира, Умино Микио, Абирү Михо гэхчлэн монгол судлаачид монголын уран зохиолыг судалж, япон хэлнээ орчуулах ажилд үнэтэй хувь нэмэр оруулсан билээ.

Энэхүү судалгаагаар Ч. Лодойдамбын “Солонго” өгүүллэгийн япон орчуулга болон Акүтагава Рюүносүкэгийн “Хамар” өгүүллэгийн монгол орчуулгыг хиймэл оюуны хийсэн орчуулгатай харьцуулж, үндэсний онцлог, соёлын ялгааг илэрхийлэх үг хэллэгийг хэрхэн орчуулсныг ажиглах болно.

Ч. Лодойдамба “Солонго” өгүүллэгээ 1958 онд бичсэн бол монгол судлаач, орчуулагч Абирү Михо 2017 онд япон хэлнээ орчуулж “Ч. Лодойдамбын өгүүллэгийн түүвэр – Хайр жигшил” нэртэйгээр хэвлэн гаргажээ. Тус өгүүллэгийн түүвэрт Ч. Лодойдамбын “Чулуун”, “Гэрээслэл”, “Хайр жигшил”, “Солонго” гэсэн дөрвөн өгүүллэгийн япон орчуулга багтсан байна.

⁵⁰中見立夫 (2009) 『「元朝秘史」渡来のころ—日本における「東洋史学」の開始とヨーロッパ東洋学、清朝「辺疆史地学」との交差』『東アジア文化交渉研究』別冊 4、p.3-26 <https://kansai-u.repo.nii.ac.jp/record/2407/files/01_nakami.pdf> (2024/9/26)

Д/д	Монгол эх	Япон орчуулга	Хиймэл оюуны япон орчуулга
1.	Адууны түрүү зэлэн дээр очоод зогсоход аав минь хазаараа барин том том алхалж ирээд,... (хуу.370)	馬群の先頭が ^ゼ ^ル 繫留網（家畜を繋ぎ止めるために地面に張った網。牝馬の搾乳のため、仔馬を繋いでおくのに用いる。）の辺りまできて止まると、父さんが 頭絡 （ハザール：馬の頭部に装着する馬具。おもがい。）を手に大股で近づいてきて、(49頁)	馬の先頭の杭のところに行って立っていると、父が 手綱 を持って大股で歩いてきて、
2.	Би морио уяад гэр рүүгээ хүнд цуваа чирэн гэлдэрч явахад Дорж гуай гэрээсээ гарч дөрвөн морь руу очоод чөдрийг нь авч, адуу руу хөөв. (хуу.371)	馬を繋ぎ、びしょ濡れでずっしりと重くなった合羽を引き摺るようにゲルの方へゆっくりと歩いていると、隣のゲルからドルジさんが出てきて、さっきの四頭の馬の 足枷 （チュドル：放牧中馬が遠くに行かないよう、後脚と前脚を固定するための革製の道具。）を解き、馬群の方へと追いつた。(50頁)	私は馬を繋いで家に向かい、重い荷物を引いてゴトゴトと進んでいると、ドルジさんが家から出てきて、四頭の馬のところに行き、 ハミ を取って馬を追い立てました。
3.	Ингэж үнэндээ Солонгын хажуугаар Навч гуай завшиж ёстой л морьтын хишиг явганд гэдэг болдог байв. (хуу.376)	こんな訳でソロンゴのお陰でナブチさんもおこぼれに預り、まさしく<騎乗の 恵み が徒歩にまで>（騎馬による遠征や狩りの獲物などが皆に分け与えられることから、お裾分け、おこぼれなどを表す言い回し。）という具合になっていた。(58頁)	こうして本当に、ソルゴンの横でナフさんが横取りして、本当に 馬の恩恵を受ける ことになるのだった。
4.	Сумын наадам болоход баг бүр том майхан барьж, эсгий дэвсээд айраг сөгнөж, тэр	郡のナーダム では村（バグ、ソム（郡））の下の行政	郡の祭りの 時、各 チーム は大きなテントを建

	багийн ардууд тэндээ очиж том хултай айргаа шимэн ууж, аж амьдрал аливаа нэгэн зүйлийн тухай хөөрөлдөн ярилцдаг. (хуу.379)	単位。ここでは「村」と訳す。) 毎に大きな天幕を張り、中にはフェルトの敷物が敷かれ、大鉢に馬乳酒が用意される。村の住民はそこを訪れ、大きな椀に注がれた馬乳酒を傾けながら、日々の話題や四方山話に花を咲かせるのだった。(61頁)	て、フェルトを敷いてアイラグを冷やし、そのチームの人々がそこに集まり、大きなコップでアイラグを飲みながら、生活や様々なことについて話し合う。
5.	Энэ хооронд Солонго бид хоёр сайн танилцаж нэг орой Навч гуай Сүрэн хоёр нэг тал, Солонго бид хоёр нэг тал болж мэлхий тоглоон, шагай шүүрэв. (хуу.375)	その間僕とソロンゴはすっかり打ち解け、ある晩などはナブチさんとスレンが組み、僕とソロンゴが組んで シャガイ （羊のくるぶしの骨、距骨。サイコロやおはじきなどの遊び道具として使われる。「亀並べ」は亀の形に並べたシャガイを、サイコロの目によって取っていく、持ち手の数を競う遊び。）で 亀並べ ^{ゲーム} の遊戯をした。(57頁)	その間に、ソルゴと私は親しくなり、ある晩、ナフさんとスレンが一方、ソルゴと私がもう一方になって カエル を捕まえたり、 シャガイ を取ったりして遊びました。

Эхний өгүүлбэрийн “зэл”-ийг 繫留綱 хэмээн ханзаар бичиж “ゼル” (зэрү) гэж галигласан байна. Мөн зүүлт хэсэгт “Мал уяхын тулд газарт бэхэлсэн олс. Гүү саах үед унага уяхад ашигладаг” гэж тайлбарлажээ. Харин хиймэл оюун “зэл”-ийг 杭 буюу “гадас” гэсэн үгээр орчуулжээ. Мөн дараагийн өгүүлбэрт “хазаар”-ыг 頭絡 гэж орчуулаад зүүлт хэсэгт “ハザール (хазаарү): морины толгой хэсэгт өмсгөх хэрэгсэл” гэсэн байх бол хиймэл оюун 手綱 буюу жолоо, морийг жолоодоход ашиглах хэрэгсэл гэж орчуулсан байна.

Хоёр дахь жишээ өгүүлбэрт орчуулагч “чөдөр”-ийг 足枷 гэж орчуулаад зүүлт хэсэгт “チュドル(чүдорү): морийг хол явахаас сэргийлж хойд, урд хөлийг бэхлэх зориулалттай арьсан хэрэгсэл” гэж тайлбарласан бол хиймэл оюун ハミ буюу амгай гэх үгээр ташаа орчуулжээ.

Гурав дахь жишээнд “морьтын хишиг явганд” гэдгийг орчуулагч япон хэлнээ үгчилж орчуулан “морьтнууд холын аян, ан агнуурын олзоо бусдад тарааж, хишиг хүртээх үйлийг илэрхийлдэг хэллэг” хэмээн нэмэлт тайлбар бичжээ. Үүнийг хиймэл оюун 馬の恩恵を受ける (морины ашиг тусыг хүртэх) гэж орчуулсан нь оновчгүй байна.

Дөрөв дэх жишээнд гарч буй “сумын наадам”-ыг орчуулагч ナーダム (наадамү) гэж галиглаж бичсэн байхад хиймэл оюун 祭り буюу “баяр наадам” гэсэн өргөн утгаар нь орчуулжээ.

Хиймэл оюун “наадам” үгийн урд “монгол” гэж залгаж бичихэд モンゴル・ナーダム (монгорү наадамү) гэж зөв орчуулсан боловч “сумын” болоод урдаа ямар нэг тодотголгүй “наадам” гэж бичихэд “баяр наадам” гэсэн утгаар 祭り хэмээн орчуулж байсан юм. Мөн өгүүлбэрт гарах “баг”-ийг (орон нутгийн засаг захиргааны хамгийн бага нэгж) орчуулагч 村 буюу тосгон гэж орчуулаад “сумын доорх засаг захиргааны нэгж” гэсэн нэмэлт тайлбар бичсэн бол хиймэл оюун チーム (бүлэг хүн, нэг баг) гэж эндүү орчуулсан байна.

Сүүлийн тав дахь жишээ өгүүлбэрийн “мэлхий тоглон шагай шүүрэх” гэсэн монголчуудын уламжлалт тоглоом наадгайг シャガイで亀並べの遊戯(ゲーム) буюу шагайгаар мэлхий өрөх тоглоом гэж орчуулаад зүүлт хэсэгт “シャガイ(Шагай): Хонины шагайн яс, шоо, охажики зэрэг тоглоомын үед ашигладаг. 亀並べ (мэлхий өрөх) нь яст мэлхийн хэлбэрээр өрсөн шагайг шоо хаяж, буусан нүдний дагуу шагай түүж, хамгийн олон шагай түүсэн нь хожно” хэмээн тайлбарлажээ. Харин хиймэл оюун カエルを捕まえたり、シャガイを取ったり гэж орчуулсан нь оновчгүй байна. Хиймэл оюуны орчуулгыг үгчлэн монгол хэлнээ буулгавал “намгийн мэлхийг барьж, шагай авч...” болно. Мэлхий гэсэн үгийг яст мэлхий (亀) бус намгийн мэлхий (カエル) гэж орчуулсан байх ба монголын уламжлалт тоглоом наадгай гэсэн утгаар бус үг нэг бүрийг үгчилж буруу орчуулсан байна.

Японы богино өгүүллэгийг хиймэл оюунаар орчуулж үзэх нь

Энэ хэсэгт японы зохиолч Акүтагава Рюүносүкэгийн “Хамар” өгүүллэгийн монгол орчуулгын хоёр хувилбарыг хиймэл оюуны орчуулгатай харьцуулж үзнэ.

Акүтагава Рюүносүкэ “Хамар” өгүүллэгээ 1916 онд бичиж Шиншичо утга зохиолын сэтгүүлд анх хэвлүүлж байжээ. Уг өгүүллэг урт хамраасаа болж бусдын элэг доог болж буй ламын тухай өгүүлдэг.

Д/д	Япон эх	Монгол орчуулга	Хиймэл оюуны монгол орчуулга
1.	禅智内供の鼻と云えば、池の尾で知らない者はない。長さは五六寸あって上唇の上から顴の下まで下っている。(18 頁)	Зэнти ламын хамар ямар вэ гэдгийг Икээнноод хүн болгон мэднэ. Ламтны хамар уртаашаа таваас зургаан сун буюу уруулаа өнгөрөөд доод эрүүнээсээ доош унжина. (Орос хэлнээс орчуулсан Д. Цоодол) Хамба ламын хамар гэхээр цөөрмийн адагт мэдэхгүй хүн гэж үгүй. Уртаараа тав зургаан сун бөгөөд дээд уруулын дээрээс аваад эрүүний доод хүрнэ. (Япон хэлнээс орчуулсан Ц. Онон)	Зэнчи Найгүгийн хамрын тухайд гэвэл, Икэ голын эрэг дээр мэдэхгүй хүн үгүй. Түүний урт нь тав зургаан сун хэмээн хэлэгдэх бөгөөд дээд уруулын дээгүүрээс эхлээд эрүүгийн доод хэсэг хүртэл унждаг.

2.	だから内供の眼には、紺の水干も白の帷子もはいらない。(19 頁)	Энэ зангаасаа болоод тэр хүмүүс хөх хүрэм өмсөж үү, цагаан кимоногоор гоёж уу, эсвэл эгэл хүрэн бүрхтэй явна уу, үгүй юу гэдгийг огтхон ч ажигладаггүй байв. (Д. Цоодол) Тийм ч учраас хамбын нүдэнд хөх хантааз , цагаан малгай зэрэг бол огт өртөхгүй. (Ц. Онон)	Тиймээс Найгүгийн нүдэнд цэнхэр ускан ч, цагаан хөвөн дээл ч ордоггүй байв.
3.	塔の屋根には霜が下りているせいであろう。まだうすい朝日に、 九輪 がまばゆく光っている。(22 頁)	Дээвэр дээр хяруу унажээ. Бүрэн цайгаагүй үүрийн гэгээнд сүмийн хамаг л чимэг зүүлт улам ч гоёор гялалзана. (Д. Цоодол) Суваргын оройд хяруу унасан болоод ч тэрүү бүдэг гэрэлтэх өглөөний наранд хүрднүүд нүд гялбам гялалзаж байна. (Ц. Онон)	Сүмийн дээвэрт хяруу бууснаас болсон байх. Өглөөний нарны шингэн туяанд 九輪 (күрин) гялалзан харагдана.

Эхний жишээ өгүүлбэрт 寸 буюу уртын хэмжүүрийг “сун, сүн” гэсэн хоёр янзаар орчуулжээ. Эртний япон хэлний толиос⁵¹ харвал, 1 寸 нь 3.03 см-тай тэнцэх учир “тав зургаан сүн” нь ойролцоогоор 15 – 18 сантиметрийг илэрхийлэх юм. Иймд 寸-ийг орчуулахдаа сантиметрээр орлуулах эсхүл зүүлт нэмж тайлбарлах нь зүйтэй болов уу.

Хоёр дахь өгүүлбэр дэх японы үндэсний хувцасны нэг болох 水干(сүикан)-г “хөх хүрэм”, “хөх хантааз” буюу ойролцоо утгатай үгээр орлуулж орчуулжээ. Харин хиймэл оюун “цэнхэр ускан” гэж орчуулсан нь тун оновчгүй байна. Угтаа 水干(сүикан) нь хэиан он тооллын үеийн доод зиндааны эрэгтэй хүний өмсдөг хувцас байсан боловч яваандаа дээд зиндааны, өндөр албан тушаалтай хүний өмсдөг хувцас болсон байна.⁵²

Гурав дахь жишээ өгүүлбэрийн 九輪 нь буддын шашны үг бөгөөд суваргын оройд байрлах есөн цагаригийг ийн нэрлэдэг. Монгол орчуулгын хоёр хувилбарт 九輪 (күрин)-ийг “чимэг зүүлт”, “хүрд” гэж орчуулсан байх бол хиймэл оюун “九輪 (күрин)” гэж галиглажээ.

Дээрх гурван жишээ өгүүлбэрийн орчуулгаас харахад, хиймэл оюун япон эхийн үг нэг бүрийг шууд утгаар нь монгол хэлнээ буулгасан байх бөгөөд найруулгын хувьд алдаатай байна.

⁵¹ 中村幸弘 (2007) 『ベネッセ全訳古語辞典』改訂版、多摩：ベネッセコーポレーション、p.711

⁵² Touken World ホームページ「平安時代の服装とは」 < <https://www.touken-world.jp/tips/51207/> > (2024/9/26) (Хэиан он тооллын үеийн хувцас хэрэглэлийн тухай)

Мөн “Хамар” өгүүллэгт буддын шашинтай холбоотой үг хэллэг олон гардаг. Өгүүллэгт хэдэнтээ давтагдах 寺-г монгол хэлнээ “сүм, хийд” хэмээн хоёр янзаар орчуулжээ.

Япон эх: 寺の内には、僧坊が隙なく建て続いて、湯屋では寺の僧が日毎に湯を沸かしている。従ってここへ出入する僧俗の類も甚だ多い。

1. **Сүм** дотроо лам нарын тус тусдаа суух олон бяцхан өрөөтэй, сүмийн халуун ус өдөр болгон ажилладаг байв. Сүмд ирдэг лам, эгэл сүсэгтэн ер бусын олон ажээ. (Д. Цоодол)
2. **Хийдийн** дотор лам нарын сууц завсаргүй шахам зэрэгцэн баригдсан байх агаад халуун усны газарт нь өдөр бүр лам нар ус буцалгаж байдаг болохоор орж гарах лам хар хүний тоо тийм ч цөөн бус. (Ц. Онон)
3. **Сүмийн** дотор талд лам нарын өргөөнүүд нягтхан байрласан бөгөөд халуун усны газарт сүмийн лам нар өдөр бүр ус халааж байна. Тиймээс энд лам болон энгийн иргэд ихээр орж гарч байна. (ChatGPT)

“Сүм, хийд” ямар ялгаатай талаар судалж үзвэл, монголч эрдэмтэн Позднеевийн 1876 – 1879 оны хооронд монгол нутгаар аялж явахдаа бичсэн тэмдэглэлд “Сүм нь оросын “кумирня” буюу мөргөлийн газар гэдэг үгтэй адилхан утгатай. Тиймээс халхууд лам нарын ойр орчимд нь байран суурин суудаггүй, тал хээрээр нүүдэллэж, баяр ёслол, их хуралтай өдрүүдэд цугладаг эргэл мөргөлийн газрыг “сүм” гэж нэрлэнэ. Харин хийд хэмээх нэршлийн тухай Халхад даяанч лам нарын суудаг мөргөлийн газрыг нэрлэхэд ашиглана. Зүйл зүйлийн гавьяа байгуулсан, мэргэн, даяанч лам нар хийдэд шавилан сууна. Буддын шашин Халхад дэлгэрч дэвжих үед эдгээр нэршлийг сайтар ялгаж ашиглаж байсан нь тодорхой боловч өдгөө төдийлөн нарийн ялгаж салгахаа больжээ”⁵³ гэжээ. Мөн Дэмбэрэл (2007) Япон – монгол толиос харвал, “сүм”, “дуган”, “хийд”, “сүм хийд” гэж орчуулсан байгаа нь орчин үед “сүм, хийд”-ийг ялгалгүй ашиглах болсныг гэрчлэх болов уу.

Акүтагава Рюүносүкэ “Хамар” өгүүллэгээ Хэиан он тооллын үеийн (794 – 1180) 今昔物語集 (Эрт эдүгээгийн үлгэрүүд) дэх 池尾禅珍内供鼻語 (Икэ-но-Огийн Зэнчин ламын хамрын тухай үлгэр)-ээс сэдэвлэн бичсэн гэж үздэг. Эрт эдүгээгийн үлгэрүүд нь японы эртний уран зохиолын сор бүтээлийн нэгд зүй ёсоор багтах бөгөөд Хятад, Энэтхэг зэрэг азийн олон орны үлгэрүүдээс бүрдсэн байдаг.

Үүнээс гадна, дараах буддын шашинтай холбоотой үгсийн орчуулгыг харьцуулж үзэв.

Япон эх	Монгол орчуулга	Хиймэл оюуны орчуулга
内典外典	Бурханы шашны ном судар (Д. Цоодол) Судар ном (Ц. Онон)	Дотоод ба гадаад судар (Буддын шашны болон Буддын шашнаас гаднах сургаал, судрууд)
目連	Мандгаляна (Д. Цоодол) Монголжийбуу (Ц. Онон)	Моголян
舍利弗	Шарипутра (Д. Цоодол) Шаарийбуу (Ц. Онон)	Шарилөв
竜樹	Нагаржунай (Д. Цоодол)	Нагаржунай

⁵³ Позднеев, А.М. (2023). Монгол дахь буддын сүм хийд, лам хуврагуудын аж байдал, лам нар, ард иргэдийн харилцааны тухай тэмдэглэл. Хуу.24.

	Нагаржунай (Ц. Онон)	
馬鳴	Асвагхоша (Д. Цоодол) Ашва гүүш (Ц. Онон)	Мянгарт, Ашвагхоша
法華經	Ариун лянхуаны аварга хөлгөн судар (Д. Цоодол) Цагаан лянхуа судар (Ц. Онон)	Лотосын ном

Эдгээр орчуулгуудаас харахад, бурхад хийгээд хүний нэрийг орчуулагч өөр өөрийнхөөр галигласан байна. Дээрх зургаан нэрээс зөвхөн 竜樹-г хоёр орчуулагч болон хиймэл оюун “нагаржунай” хэмээн адилхан орчуулсан бол үлдсэн таван үгийг өөр өөрөөр орчуулжээ. Хиймэл оюун 目連 болон 馬鳴 хоёрыг орчуулагчаас тэс ондоо буюу Моголян, Мянгарт гэж орчуулсан нь хиймэл оюун (ChatGPT) мэргэжлийн үг хэллэг, тэр дундаа шашны холбогдолтой үг хэллэгийг буруу орчуулж буйг харуулж байна.

Дүгнэлт

Ч. Лодойдамбын “Солонго” өгүүллэгийн япон орчуулга болон Акүтагава Рюүносүкэгийн “Хамар” өгүүллэгийн монгол орчуулгын хоёр хувилбарыг хиймэл оюун (ChatGPT)-ны орчуулгатай харьцуулж үндэсний онцлог, соёлын ялгаатай үг хэллэгийг хэрхэн орчуулсныг ажигласны үр дүнг дараах байдлаар дүгнэв.

Монгол зохиолын япон орчуулгын тухайд:

1. Орчуулагч “Солонго” өгүүллэгийг япон хэлнээ орчуулахдаа үндэсний онцлог бүхий үг хэллэг бүрд тайлбар, зүүлт нэмсэн байх бөгөөд үг нэг бүрийг товч, ойлгомжтой тайлбарлажээ.
2. Хиймэл оюун (Chatpgt) “Солонго” өгүүллэгийн жишээ өгүүлбэрийг япон хэл рүү орчуулахдаа үндэсний онцлог бүхий үг хэллэгийг япон хэлний утга ойролцоо гэж үзсэн үгээр орлуулж (ханзаар) бичсэн байх боловч адилхан бичлэгтэй өөр утга илэрхийлдэг үгсийг зөв утгаар нь орчуулж чадахгүй байгааг дөрөв болон тав дахь жишээ өгүүлбэрээс харж болно.

Япон зохиолын монгол орчуулгын тухайд:

1. Хоёр орчуулагч болон хиймэл оюуны орчуулгад 寸 (сүн) уртын хэмжүүрийг орчуулалгүй шууд хэрэглэсэн нь уншигчдад ойлгомжгүй санагдах болов уу. Иймд сантиметрт шилжүүлэх эсхүл зүүлт хэсэгт нэмэлт тайлбар оруулах нь зүйтэй гэж үзэж байна.
2. Хамар зохиолын хоёр орчуулгаас харахад япон хэлний үндэсний онцлог бүхий үг хэллэгийг монгол хэлнээ буулгахдаа галиглах, тайлбарлах аргаас илүүтэй ойролцоо утгатай монгол үгээр орлуулж орчуулсан тохиолдол их байсан бол хиймэл оюун галиглан буулгах нь олон байна.
3. Хиймэл оюун япон зохиолын жишээ өгүүлбэрийг монгол хэл рүү орчуулахдаа үг нэг бүрээр, үгчилж орчуулж байсан бөгөөд утга, найруулгын хувьд алдаатай орчуулах нь их байна.

Үндэсний онцлог, соёлын ялгаатай үг хэллэгийг хиймэл оюун (ChatGPT) утга санаа, найруулгын хувьд ойлгомжгүй, ташаа орчуулах тохиолдол элбэг байгаа тул давхар орчуулагч хянан, тайлбар хийх нь зүйтэй хэмээн үзэж байна.

Номзүй

Монгол эх сурвалж

1. Акүтагава, Р. *Хамар*. (Орчуулсан Д. Цоодол) <http://uuriin-tuya.blogspot.com/2013/01/blog-post_29.html> (2024/9/27)
2. Акүтагава, Р. (2011). *Хамар*. УБ. (Орчуулсан Ц. Онон)
3. Гүрбазар, Р. (1996). *Орчуулгын онол дадлагын үндэс*. УБ.
4. Дашдаваа, Д. (1972). Үндэсний онцлог бүхий үг, хэлц үгийг орчуулах нь. *Орчуулах эрдэм – I*. УБ.
5. Дэмбэрэл, С. (2007). *和毛辞典 = Япон Монгол толь бичиг*. УБ.
6. Лодойдамба, Ч. (1977). *Түүвэр зохиол*. Улсын Хэвлэлийн Газар.
7. Позднеев, А.М. (2023). *Монгол дахь буддын сүм хийд, лам хуврагуудын аж байдал, лам нар, ард иргэдийн харилцааны тухай тэмдэглэл*. Эрдэм гэгээрэл паблишинг. Хуу.24.

Япон эх сурвалж

1. 芥川龍之介『鼻』 <https://www.aozora.gr.jp/cards/000879/files/42_15228.html> (2024/9/27)
2. 東京新聞ホームページ (2024)「芥川賞作家・九段理江さん「受賞作の5%は生成AIの文章」発言の誤解と真意、AIある時代の創作とは」 <<https://www.tokyo-np.co.jp/article/310036>> (2024/9/26)
3. 中見立夫 (2009)「『元朝秘史』渡来のころ—日本における『東洋史学』の開始とヨーロッパ東洋学、清朝「辺疆史地学」との交差」『東アジア文化交渉研究』別冊4、p.3-26
4. 中村幸弘 (2007)『ベネッセ全訳古語辞典』改訂版、多摩：ベネッセコーポレーション、p.711
5. ロドイダンバ、Ch (2017)『恋と嫌悪：ロドイダンバ短編集』阿比留美帆訳、ウランバートル：ロドイダンバ基金：S. ナサンザヤ <https://kansai-u.repo.nii.ac.jp/record/2407/files/01_nakami.pdf> (2024/9/26)
6. 李在鎬 (2024)「ChatGPTのインパクトと今後の外国語教育の方向性について」『大学英語教育学会中国・四国支部研究紀要』、p.31-44
7. Ravdan, E., Dolgor, S. (2013)『モンゴル遊牧文化用語辞典』モンゴル国立大学国際言語文化学部日本学科
8. Touken World ホームページ「平安時代の服装とは」 <<https://www.touken-world.jp/tips/51207/>> (2024/9/26)

要約

生成 AI は現代社会において不可欠な存在となりつつある。AI はさらに発展し、人の心や感情と深く結びついた文学の世界にも入り込んだ。その一例は文学作品の翻訳である。本研究では、Ch.ロドイダンバ作の小説『ソロンゴ』の日本語訳及び芥川龍之介作の小説『鼻』のモンゴル語訳を生成 AI (ChatGPT) による翻訳と比較し、異なる文化に関わる言葉を生成 AI が翻訳できるかを検討する。